

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-4</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-12</i>
<hr/>	
1.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	6-12
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай/	12

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 10 дугаар сарын 02-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 27 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Х.Баттулга;
Эмнэлгийн чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Л.Мөнхбаатар, С.Одонтуяа,
Дав.Цогтбаатар.

Нэг.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Мөрдөн байцаах албаны дарга П.Очбадрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Баасанжаргал, Г.Уянгахишиг, Х.Тэмүүжин нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Мөрдөн байцаах албаны дарга П.Очбадрах нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Д.Ганбат, Х.Баасанжаргал, О.Номинчимэг, М.Нарантуяа-Нара, Б.Бат-Эрдэнэ, Д.Цогтбаатар, Г.Уянгахишиг нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатарын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг хүнийг саатуулсан үеэс эхлэн тооцох бөгөөд энэ хуулийн 22.2-т заасныг танилцуулна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг хүнийг саатуулсан үеэс эхлэн тооцох бөгөөд энэ хуулийн 22.2-т заасныг танилцуулна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-т заасны дагуу “Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй бол хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно.” гэж заасны дагуу горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9

Бүгд: 17
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-т заасны дагуу “Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй бол хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно.” гэж заасны дагуу гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зарлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17

58.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 68.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 10 минут үргэлжилж, 22 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 77.3 хувийн ирцтэйгээр 12 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин
Д.Сүхбаатар” танхим 13 цаг 35 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хороодын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Ингээд Байнгын хороонд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн байна. Баярмагнайн Баярбаатар ирсэн байна. Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн. Одонгийн Цогтгэрэл гишүүн ирсэн, Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн. Жудгийн Баярмаа ирсэн. Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн. Батын Батбаатар гишүүн ирсэн. Энхбатын Болормаа гишүүн, Нямтайширын Номтойбаяр гишүүн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн байна.

Ингээд ирц бүрдсэн тул хуралдааныг эхлүүлъя ээ.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 10 сарын 15-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Дөрвөн суудал байгаа.

1. “Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

2. “Монгол Улсын улсын Их улсын Их Улсын Их Хурлын 2024 оны ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

3. Байнгын хорооны тогтоолын төсөл “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох тухай”,

4. Байнгын хорооны тогтоолын төсөл “Цаглавар батлах тухай”.

Ингээд 4 хэлэлцэх асуудал байна. Үүнээс “Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл байж байгаа. Энэ журам баталсан танилцуулах хүмүүс маань өнөөдөр зөвшөөрөл аваад явсан. Хүрэлцэн ирэх боломжгүй байна гэсэн ийм зөвшөөрөл авчихсан байгаа, чөлөө авсан байгаа. Тэгэхээр энийг гишүүдийнх нь горимын санал гаргасны дагуу хойшлуулъя гэж ийм санал гарч ирж байна. Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Энэ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заагдсан хяналтын сонсголыг зохион байгуулах журам бид нар батлах гэж байгаа юм. 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хамгийн гол асуудал бол Улсын Их Хурлын гишүүний бас нэг онцгой бүрэн эрх нь Улсын Их Хурлын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих. Бид нар ард түмнийг төлөөлөх, дээрээс нь тодорхой томилгоо хууль батлах энэ эрхээ бол нэлээн сайн бас хууль санаачилж батлах эрхээ нэлээн сайн хэрэгжүүлдэг байсан. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрхээ тийм сайн хэрэгжүүлж чаддаггүй байсан. Тэгвэл 2019 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад үүний дагуу

2020 онд энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг бас миний бие болон бусад гишүүдийн хамт санаачилсан. Батлагдаад өнөөдөр ингээд энэ хяналт шалгалт маш чухал юм байна аа. Энэ бас төрд нүүрлэсэн хулгай, албан тушаал, эрх мэдлээ ашигладаг байдал энэ бүгдийг цэгцлэхэд маш чухал гэдэг нь харагдсан. Хөгжлийн банкны сонсгол, нүүрсний сонсгол, эмийн хяналтын сонсгол гээд олон сонсголуудаар хаана ямар хулгай зэлгий байдаг хаана ямар асуудал үүсдэг вэ? Энэ бүхэн бас ард түмний бас мэдэх эрх хангагдаж тодорхой хууль зөрчсөн хулгай хийдэг нөхдүүд хариуцлагаа хүлээсэн. Гэхдээ бас яг бүрэн төгс болчихсон бүүр их сайн болчихсон нь бас үгүй байгаад байгаа юм. Тийм болохоор энэ хуулийг бас сайжруулах, хуулийн хэрэгжилтийг өөр илүү хангах үүднээс энэ журмыг бас боловсруулж оруулж ирж байна гэж ойлгож байгаа. Тэгээд одоо ингээд журам харахаар чинь бас 5-д нь сонсголын тайлан тэмдэглэл гаргаад архивлаад л дуусчих гээд байна л даа.

Урьд нь бас ингээд л сонсголын тайланг Их Хурал дээр хэлэлцээд сонсоод л ингээд л өнгөрчихдөг. Тэгээд л алга болчихдог. Тухайн үедээ баахан нөхдүүд л хууль зөрчсөн, баахан нөхдүүд хулгай хийчихсэн, баахан нөхдүүд гэмт хэрэгт холбогдсон. Зарим Их Хурлын гишүүд, зарим албан тушаалтнууд түдгэлзээд ингээд явсан. Гэсэн мөртөө өнөөдөр яг тодорхой хуулийн дагуу шүүхээр ямар ял шийтгэл авсан эс үгүй бол цагаадсан энэ бүхэн тодорхой байдаггүй. Тийм болохоор хяналтын сонсголын үр дүн хяналтын сонсголоос яригдсан асуудлыг тийм үү бодитой хэрэгжүүлэх, энэ үр дүн гаргах тал дээр энэ журамдаа бас нэг тодорхой юм оруулж өгөхгүй бол бас л урьд нь бас яг л ийм л байсан л даа.

Хяналтын сонсголын тайлан тэмдэглэл гаргаад архивлаад л өнгөрчихдөг. Одоо энийгээ л журамлаж байна. Тийм болохоор өнөөдөр харин ашигүй бас ирээгүй байгаа юм шиг байна. Ажлын хэсгийн нөхдүүд. Ажлын хэсгийн нөхдүүд энийг бас журмаа дахиад сайн боловсруулж орж ирээч ээ журмаа. Энэ дээр хяналтын сонсголын үр дүнг заавал гаргадаг байх, эргээд мэдээлдэг байх. Үнэхээр хяналтын сонсголоор хүн хэлмэгдүүлчихсэн бол хэлмэгдүүлчихжээ гээд уучлалтаа хүлээгээд олон нийтэд мэдээлдэг байх ёстой.

Хяналтын сонсголын үр дүнгээр үнэхээр хууль зөрчсөн хулгай хийсэн нь тогтоогдсон бол энэ хүн ингээж хулгай хийж, хууль зөрчсөн нь тогтоогдсон байна аа. Энэ бол хяналтын сонсголын үр дүн байлаа гэдгээ бас олон нийтэд зарлаж мэдээлдэг байх ёстой. Хяналтын сонсголын үр дүнгээр тодорхой гэмт хэрэгт холбогдсон бол тэр гэмт хэрэгт холбогдсон улсуудыг шалгаад хурдан хугацаанд үнэн бодит байдлыг нь тогтоодог байх ёстой. Ингээж мэдээлдэг байхгүй бол тэгээд зүгээр нэг сонсгол хийгээд шоудаад өнгөрчихдөг. Ард нь ард түмэн юу болсон бэ? Үр дүн чинь хаана байна? Хариуцлага тооцсон чинь хаана байна. Та нар тэгээд л нэг сайхан шоудаад л өнгөрөх юм. Хамгийн гол нь хариуцлага тооцох ёстой шүү дээ. Үр дүн гарах ёстой шүү дээ гэдгийг байнга нэхэж байгаа. Тэгвэл энэ нэхэж байгаа асуудлыг нь журамдаа оруулж өгөөд энэ журмаараа нэг цэгцэлдэг тэгээд ард түмэнд эргээд тайлагнадаг, мэдээлдэг ийм үр дүн гарсан юм гээд ард түмэн мэдэх эрх нь бүрэн хангагдмаар байгаа юм аа.

Тийм болохоор энэ журмаа бас сайжруулах тал дээр дахиад нэг жаахан жаахан ажиллаач.

Ж.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Өнөөдөр энэ Байнгын хорооны хурал дээр байсан Хяналт шалгалтын тухай хууль, сонсголын тухай асуудал хойшлох нь л дээ. Ер нь энэ өнгөрсөн хугацаанд бас тодорхой сонсголууд болсон. Энэ сонсголуудын үр дүн олон зүйлүүдийг харахад бид нарт бүр нэг дүгнэлт хиймээр нэг зүйл гарч байгаа нь сонсголттой холбоотой. Сонсголын даргалагчийн асуудал. Хүсэн хүлээж байгаа үр дүн нь өөр байдаг. Гэтэл яг одоо хуульдаа байгаа журамдаа байгаа олон зүйлээр сонсголыг, өнгөрсөн сонсголуудыг эрх баригчид даргалж ирж байсан. Нүүрсний сонсгол байсан эрх баригч эрх баригч, Засгийн газрын Хууль зүйн сайд нь сонсголын дарга. Тэр чинь хэн нь хэнийгээ хянаж хэн дээрээ хяналт тавих гээд байгаа билээ. Хувь хүний асуудал биш. Яг одоо АН-ын бүлгээс санаачилга гаргаад гишүүдийн энэ гарын үсэг хүрээд ногоон автобусны сонсгол болсон. Эрх баригчдаас хун нь тавигдаад л. Энэ нь заавал тэр энэ хүндээ бас биш даргалж байгаа хүндээ бас биш. Энийг суурь асуудал нь энийг өөрчлөхгүйгээр тэр цөөнхөөс энэ сонсголыг зохион байгуулах даргалагчийн асуудлыг тавихгүйгээр энэ сонсгол гэдэг чинь цааш цаашидаа бид нар тэр сонгодог парламент руу алхаж байна гэж байгаа энэ олон олон зүйлүүд чинь эцсийн дүндээ энэ бүх зүйл чинь ямар ч үр дүнгүй болох юм байна лээ. Олонх засаглаж байдаг. Өөрснөө өөрсдийгөө хянадаг. Өөрсдөөсөө бүрэлдэхүүн гаргадаг, өөрснөө даргалдаг, өөрснөө энэ тайлан юмаа өөрснөө гаргадаг.

Тэгэхээр мянга гоё юм яриад энэний цаана тэр жижигхэн юм шиг мөртөө тэр сонсголыг хяналтын сонсголыг Түр хороо байгуулж байгаа сонсголыг цөөнхөөс хийнэ гэдэг энэ зүйл

заалтыг хууль дүрэм журамдаа бид нар тусгахгүйгээр ер нь үр дүн гэж байхгүй юм байна лээ шүү. Өнгөрсөн сонсголуудыг харж байхад. Тэгэхээр энэн дээр цааш цаашид бас анхаарч ажиллах тэгээд АН-ын бүлгийн зүгээс бас энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд яг энэ чиглэлээр нэмэлт, өөрчлөлтийн хуулийг бас өргөн барих шаардлагатай гэдэг ийм байр суурьд хүрч байгаа гэдгийг бас та бүхэндээ дуулгая.

Ж.Бат-Эрдэнэ: Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Энэ дээр нэг горимын чанартай санал байна аа. Хуулиа харахаар бид нар 126 чинь тэр чигээрээ сонсгол явуулах журам байгаа шүү дээ. Тэгээд 126.5 дээр тэр нарийвчилсан журмыг батална гэгчихсэн байгаа юм. Тэгвэл буцаагаад яг хууль хэлэлцэх явцад яг ямар асуудлыг шийдэж чадаагүй учраас нарийвчилсан журам баталъя гэдэг энэ заалтыг оруулсан юм болоо гэдэг сонирхолтой байна. Ер нь бол энэ удаагийн парламентаар бид нар журмуудынхаа тоог цөөлье. Хуулиар зохицуулах ёстой асуудлыг журмаар биш хууль руугаа оруулъя гэдэг ийм стратеги барьж байгаа мөртөө одоо ингээд яг журмын төслийг нь харахаар айхтар сүртэй яг тусдаа журам байгаад байхаар асуудлууд байхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд гишүүдийн хэлж байгаа саналуудыг сонсохоор бол зайлшгүй хуульд байх ёстой журмууд байгаад байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол журмаар биш хуулиараа зохицуулах ёстой асуудлууд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энийг ер нь бол тусдаа заавал ингэж журам батлах ёстой юм уу за яах вэ хууль тогтоогч биш байсан бол хууль дээр журам батална гэгчихсэн учраас журам батлахгүй бол болохгүй байна гэдэг асуудал яригдана. Нэгэнт

хууль тогтоогчийн хувьд тэр хууль дээр байгаа хэрвээ шаардлагагүй журмаар зохицуулах шаардлагагүй гэж үзвэл нарийвчилсан журам батална гэдэг заалтаа эргээж харвал яасан юм бэ гэдэг ийм нэг санал байгаад байна.

Ж.Бат-Эрдэнэ: Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Ингээд сонсголын асуудалтай холбоотой зөндөө олон санал гарах юм байна. Тэгээд ер нь сая энэ төслөө ч авлаа ажлын хэсэг нь ч байхгүй байна. Тэгэхээр өнөөдрийн хэлэлцэх асуудлыг журам хэлэлцэх асуудлыг хойшлуулж өгнө үү, хойшлуулах санал гаргаж байна.

Ингээд шийдчихээд дараа нь ярихгүй бол дараа нь тэртээ тэргүй бараг өдөржин ярих юм шиг байна.

Бас тэгж болно. Бүлгүүдээрээ хэлэлцэж байгаад бас орж ирж болно. Тэгэхээр өнөөдөр яг ажлын хэсэг нь алга байна. Ахалж байгаа, ахалсан Улсын Их Хурлын гишүүн нь алга байна. Тийм болохоор хойшлуулъя гэсэн энэ горимын саналыг хүлээж авч байна. Санал хураана.

Хоёрдугаарт гишүүдийн хэлсэн саналтай бол санал нэг байгаа. Бид сонсгол хийдэг болсон. Энэ бол маш том шинэчлэлийг уг нь бид нарт авчирсан шүү дээ. Аливаа асуудлуудыг бид нар татаж авчраад Улсын Их Хурал дээр хяналтын сонсгол хийгээд ярьдаг, асуудлуудыг нь гаргаж ирдэг, ил болгодог, энэ бол асар том. Бид нарын хувьд бол том шинэчлэлийг бол Улсын Их Хурал маань баталж өгсөн. Энэ бол бидний хувьд бол бас аливаа зүйлийг шударга явуулах тал дээр нь бол алхам хийсэн том хуулийн өөрчлөлт өөрчлөлт байгаа шүү дээ.

Гагцхүү сая өнгөрсөн сонсголуудыг харж байхад үр дүн харагдахгүй байгаад байгаа юм л даа. Яагаад гэхээр энэ үр дүн бол өөрөө хууль хяналтын байгууллага дээр очиж байгаа. Биднээс үл шалтгаалсан шүүхийн шийдвэр бол мэдээж бид бол оролцох ийм эрх боломж байхгүй. Тэгэхээр энийгээ буцаад нэг би бол энийг харахдаа хуулийн байгууллагууд буцаад Улсын Их Хуралд яг энэний дагуу бид нар тайлангаа, хууль хяналтын байгууллагад өгдөг. Хууль хяналтын байгууллага буцаад эргээд Улсын Их Хуралд ийм ийм асуудлуудыг шийдсэн энэ нь бол Эрүүгийн тухай хууль, энэ нь Иргэний хуулиар, энэ нь Зөрчлийн тухай хуулиар шийдэгдсэн ч гэдэг юм уу ийм нэг тайлан тавих нь зүйтэй байх л гэж харж байгаа юм.

Сая Уянгахишиг гишүүний хэлж байгаачлан бид нар журмыг хуульд оруулъя гэж байгаа шүү дээ. Тэгэхгүй бол журам дээр заасан заалт гэдгээр бид нар бол цаашаа харж байгаад шал өөр зүйл хийгээд явчих гээд байгаа юм, тийм үү? Бүх салбарын хууль дээр байж байгаа журмуудыг. Зайлшгүй шаардлагатай зүйлүүдийг нь хуульд нь оруулъя гэж байгаа шүү дээ. Энэ ажлын хэсгийг миний бие ахлаад ингээд явж байгаа юм. Тэгэхээр энэ яах вэ хуульд бол бид нар заалт байж байгаа.

Дэгийн тухай хуулийн 126.5 дээр Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулах нарийвчилсан журмыг Улсын Их Хурлын тогтоолоор батална гэж. Сая Цогтгэрэл гишүүн хүртэл хэллээ шүү дээ. Даргыг нь хүртэл эрх баригчид сонголоо энэ тэр гэсэн янз янзын асуудлууд байж байна. Тийм болохоор дараагийн хурал дээр хэдүүлээ энийг магадгүй бүлэг дээрээ харж байгаад буцаж орж ирэхэд нь ажлын хэсгийг нь байлцуулаад энэ дээр нэлээн хэлэлцүүлэг явагдах байх шүү. Тийм болохоор хойшлуулъя гэсэн горимын

саналыг санал хураалт явуулъя.
Хойшлуулъя гэдгээр.

Баярмаа гишүүн зөвшөөрсөн.

Ингээд 71 хувиар санал дэмжигдсэн тул энэ асуудлыг хойшлуулъя.

Дараагийн асуудал. “Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаа. Тогтоолын төсөл дээр энэ чинь санал бас гүйцэд ирээгүй гэсэн асуудал гарч ирж байна аа.

Тийм болохоор асуудлыг хойшлуулъя гэж байна. Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Энэ 10 сарын бас цаглавар дээрээ нэг асуудал ярьчихъя гэж бодож байгаа юм аа. Монгол Улсын Их Хурлын үндсэндээ 8 чуулган хуралдана. 8 чуулганы анхны чуулган бид нар эхэлж байгаа, анхны чуулган. Тэгээд анхны чуулганыхаа эхний сардаа хэдүүлээ бас энэ төрийнхөө бодлогыг үзэгдэх хооронд нь нэг уялдаатай холбоотой болгох энэ юмандаа бас анхаарчихгүй болохгүй байгаа юм аа. Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль гэж хуулиуд бид нар баталсан. Монгол Улсын Үндсэн хуульдаа Монгол төрийн бодлого нь бас хоорондоо уялдаа холбоотой байна. Урт, дунд, богино хугацаандаа салбар дундын уялдаатай байна. Урт хугацаандаа төлөвлөгдсөн байна. Төсөвтэйгөө төсөв нь одоо төлөвлөгөөндөө нийцсэн байна гээд хууль баталчихсан.

Гэтэл одоо төсвөө өргөн барьчхаад араас нь бид нар төлөвлөгөө оруулж ирээд хэлэлцээд явж байгаа гэх мэтчилэн ингээд үндсэндээ нөгөө

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль маань амьдрал дээр бас нэг бодитой хэрэгжихгүй байгаад байгаа юм. Өнөөдөр Монгол Улсын урт хугацааны бодлогын бичиг баримт Алсын хараа- 2050 дунд хугацааны зорилтот хөтөлбөр гээд 8 хөтөлбөр батлах ёстой. Араас нь үндсэн чиглэл 5 жилийн үндсэн чиглэл, тэгээд 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тэгээд жил болгоны хөгжлийн төлөвлөгөө. Тэр төлөвлөгөөг хэрэгжүүлэх гэж л төсвөө оруулж батлах ёстой доо. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх гэж. Төлөвлөлт нь чухал төлөвлөлтдөө тааруулж бид нар төсөвлөлтөө хийх ёстой. Гэтэл одоо төсөвлөлт нь чухал болчихсон уу ерөөсөө төлөвлөгөөгөө тоодог хүн байхгүй болчихсон. Нөгөө урт хугацааны бодлого, дунд хугацааны зорилтот хөтөлбөр одоо болтол батлагдаагүй байж байгаа. Олон зорилтот хөтөлбөрүүд нь. Гэсэн мөртөө хажуугаар нь дахиад төрийн бодлогын бичиг баримт батлаад яваад байгаа. Энэ нь өөрөө бас хууль зөрчөөд байгаа. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулиа. Тэгээд энийгээ нэг үзэгдэх нэг ажлын хэсэг байгуулаад энэ асуудлаа нэг ярихгүй бол нэг их олон, баахан хуультай, баахан журамтай. Тэр нь хоорондоо уялдаатай зарим нь ерөөсөө ямар ч уялдаа байдаггүй. Ийм болчихсон байна гэж яриад байгаа мөртөө энийгээ ерөөсөө шийдэх талаар оролдлого хийхгүй байгаад байгаа байхгүй юу. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль баталж байхад бид нар Улсын Их Хурлын тогтоол гаргасан. Тэр тогтоол дотроо хүчингүй болгох хуулиудыг, хүчингүй болгох бодлогын бичиг баримтуудыг бүгдийг нь хүчингүй болгоё. Хоорондоо уялдаатай болгох бодлогын бичгээ хооронд нь уялдаатай болгоё гээд гол нь тогтоол баталчихсан юм.

Гэтэл тэр маань ерөөсөө хэрэгжихгүй байгаад байгаа юм. Тийм болохоор нэг Төрийн байгуулалтын байнгын хорооны яг эрхлэх асуудал мөн учраас ажлын хэсэг байгуулаад энэ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх энэ ажлын хэсгийг байгуулаад энэ бас хууль хоорондын давхцал, хийдэл, нийцэл, дээрээс нь ялангуяа энэ бодлогын бичиг баримтууд. Болсон болоогүй баахан бодлогын бичиг баримттай. Гэтэл Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульдаа бол ерөөсөө л урт хугацааных нь Алсын хараа 2050 байна. Дунд хугацаандаа бид нар ерөөсөө л 8 зорилтот хөтөлбөр байна. Ингээд л баталчихсан. Гэтэл үүнээс гадна хууль зөрчсөн олон бодлогын бичиг баримт бид батлаад яваад байгаа. Энийгээ нэг Төрийн байгуулалтын байнгын хороогоор бас нэг ажлын хэсэг байгуулаад энийгээ нэг цэгцлэх асуудлыг оруулчхаач ээ. Энэ одоо бас яг энэ Их Хурлын бүрэн эрх эхэлж байгаа учраас хамгийн эхэнд нь бас нэг бодлогоо цэгцлээд явах нь зөв байх аа гэдэг үүднээс бас энэ саналыг хэлж байгаа юм аа.

Тэгээд шаардлагатай бас саналын томъёолол саналаа гаргаад өгч болно.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ мэтчилэн нэлээн хэдэн зүйлүүдийг оруулах шаардлага байгаа юм аа. Бямбацогт гишүүний ярьж байгаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах зайлиггүй шаардлага бас байгаад байгаа юм. Үндсэн хуульд анх өөрчлөлт оруулж байхад Бямбацогт гишүүн, миний бие, Баттөмөр гишүүн бид хэд нийлж байгаад санал гаргаад тодорхой хөгжлийн төлөвлөлтийг хийж байх институц байгуулах ёстой гэж байгаад өнөөдрийн Эдийн засаг, хөгжлийн яамыг байгуулж байсан шүү дээ. Тэгээд энэнтэйгээ уялдуулаад энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай

хууль уялдах зайлиггүй шаардлагатай болчхоод байгаа юм.

Тийм болохоор энийг саналыг бол хүлээж авъя аа, 1 дүгээрт.

Хоёрдугаарт тэр нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам захиргааны дүрэм журмыг зохицуулах өөрөөр хэлбэл цөөрүүлэх асуудлаар Улсын Их Хурлын даргын захирамж гарсан.

Миний бие энэ ажлын хэсгийг ахалж байгаа. Тэгээд энэнээс бас асуудлууд орж ирэх байх. Тэгвэл энийг цаглавар дотроо тухай буюу ер нь бас тусгаад эд нар явчих нь зүйтэй болов уу л гэж бодож байгаа юм.

Тийм болохоор өнөөдрийн асуудлыг бас хойшлуулах зайлиггүй шаардлага бас гарч ирж байна аа.

Тийм болохоор 2 дахь асуудлыг хойшлуулъя гэдгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдсэн тул 2 дахь асуудлыг хойшлууллаа. 3 дахь асуудал дээр бас нэг ийм асуудал байна аа.

Байнгын хорооны тогтоолын төсөл Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох тухай байгаа. Дэд хорооны даргаар сонгогдохоор нэр дэвшигдэж байгаа Жамбалын Ганбаатар гишүүн Улсын Их Хурлын даргатай бас ажлын хэсэг дээр ажиллаад гадуур явж байгаа, томилолттой ажиллаж байгаа.

Тэгэхээр хэлэлцэх үү? Нэр дэвшигчийг байх байхгүйг үл харгалзаад хэлэлцэх үү? Ер нь гарчихсан. Тэгвэл хэлэлцээд явчих уу? Тэгвэл энэ дээр хэлэлцээд явчихъя. Ингээд 2 асуудлаа

батлах уу айн? Өөрөө зөвшөөрч байгаа юм.

Санал хураах уу? Өөрийг нь уг нь байлцуулах л зайлиггүй шаардлагатай л байгаа юм даа. Бас асуулт асуух ёстой уг нь.

Хойшлуулъя гэдгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

57.1 хувиар санал дэмжигдлээ. Хойшлуулж байна аа.

Байнгын хорооны тогтоолын төсөл “Цаглавар батлах тухай”.

Ингээд энийгээ хэлэлцээд явах уу? Өөр асуудал байхгүй бол энийг баталлаа.

Хэлэлцэх асуудлыг баталлаа. Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын чуулганы 10 дугаар сард Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Энэ дээр намрын

ээлжит чуулганы төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар байгаа.

Тэгэхээр энэ дээр бас нэг ийм өөрчлөлт сая эхний журмыг хойшлуулсан шүү дээ. Тийм болохоор 2024 оны 10 сарын 14-өөс 10 сарын 18-ны хооронд мягмар гарагт Байнгын хороо мягмар гарагт, нэгдсэн хуралдаан Пүрэв гарагт гэснийг 29-ний мягмар гарагт Байнгын хороо, 31-ний пүрэв гарагт нэгдсэн хуралдаан гэж хойш нь гүйлгээд тэгээд батлах уу? Хойш нь гүйлгэнэ. Өөр асуулт байна уу? Тэрийгээ хэдүүлээ батлахдаа. Өөр асуулт байна уу? Асуулт асууж, хариулт авлаа. Ингээд цаглавар баталъя гэдгээр Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглаварыг баталъя гэдгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

71 хувиар цаглавар батлагдлаа.

Ингээд хуралдаан дууссаныг мэдэгдье.

14.00

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА